

**ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

**ХӨРГӨХ ЦАМХАГ №2-ЫН УСНЫ ХАТУУЛАГ БУУРУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:
Төслийн дугаар:**

**Хөргөх цамхаг №2-ын усны хатуулаг бууруулах
ТЗБАХ-02.2020**

ДЦС-3

Улаанбаатар хот

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“ДЦС-3” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Хөргөх цамхаг №2-ын усны хатуулаг бууруулах” ажилд үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг 2020 оны 03-р сарын 20-ны өдрийн 10.00 цагаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 03-р сарын 20-ны өдрийн 10:05-д цахим системээр нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: тооцохгүй
Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо,
“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар
Хангамжийн хэлтэс: Утас: 70111304, Факс: 344111.
Веб хуудас: www.tes3.energy.mn**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
 - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол

үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.

6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт																												
ТӨӨЗ 1.1	<p>1. Тендерийн маягтын дагуу ажил гүйцэтгэх үнийн санал ирүүлэх</p> <p>2. Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь</p> <p>3. Тухайн ажлыг хийж гүйцэтгэх боловсон хүчний чадавхийн мэдээлэл</p> <p>4. Сүүлийн 1 жил (2019 он)-ийн жилийн санхүүгийн тайлан ирүүлэх. (Аудитаар баталгаажуулсан байх)</p> <p>5. Сүүлийн 2 жил (2018, 2019 он)-ийн туршлагын мэдээлэл (Аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ажил хийж гүйцэтгэсэн байна. Гэрээ, гэрээ дүгнэсэн актны хуулбар)</p> <p>6. Сүүлийн 1 жил (2019 он)-ийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.</p> <p>7. Аж ахуйн нэгжийн гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар</p> <p>8. Аж ахуйн нэгжийн товч танилцуулга</p> <p>9. Татварын албаны цахим тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй. Тендер нээсэн өдрөөр цахим системээс татаж шалгана.</p> <p>10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт</p> <p>11. Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй гэсэн тодорхойлолт ирүүлэх</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <p>1. 0.7-16.0 кгх/см2 даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах мэрэгжлийн ИТА ажилчидтай байх шаардлагатай. Үүнд:</p> <table border="1" data-bbox="375 1041 1490 1355"> <thead> <tr> <th>№</th> <th>Албан тушаал</th> <th>Хүний тоо</th> <th>Ажлын туршлага жилээр</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>Ерөнхий инженер /дулааны инженер мэргэжилтэй/</td> <td>1</td> <td>3</td> </tr> <tr> <td>3</td> <td>Хөдөлмөр хамгааллын инженер</td> <td>1</td> <td>2</td> </tr> <tr> <td>4</td> <td>Дулаан тоноглолын засварчин</td> <td>3</td> <td>2</td> </tr> <tr> <td>5</td> <td>Мэрэгжлийн оосорлогч дохиочин</td> <td>1</td> <td>2</td> </tr> <tr> <td>6</td> <td>Гагнуурчин, огтлогч</td> <td>2</td> <td>2</td> </tr> <tr> <td>7</td> <td>Цахилгаан тоног төхөөрмжийн монтер</td> <td>1</td> <td>2</td> </tr> </tbody> </table> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд:</p> <p>1. Авто кран 5 тонн – 1 ширхэг</p> <p>2. Гагнуурын аппарат – 1 ком</p> <p>3. Суурин таслагч – 1 ширхэг</p> <p>4. Цахилгаан молоток – 2 ширхэг</p> <p>5. Хөдөлмөр хамгааллын хэрэгсэлүүд <i>гэх мэт.</i></p>	№	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага жилээр	1	Ерөнхий инженер /дулааны инженер мэргэжилтэй/	1	3	3	Хөдөлмөр хамгааллын инженер	1	2	4	Дулаан тоноглолын засварчин	3	2	5	Мэрэгжлийн оосорлогч дохиочин	1	2	6	Гагнуурчин, огтлогч	2	2	7	Цахилгаан тоног төхөөрмжийн монтер	1	2
№	Албан тушаал	Хүний тоо	Ажлын туршлага жилээр																										
1	Ерөнхий инженер /дулааны инженер мэргэжилтэй/	1	3																										
3	Хөдөлмөр хамгааллын инженер	1	2																										
4	Дулаан тоноглолын засварчин	3	2																										
5	Мэрэгжлийн оосорлогч дохиочин	1	2																										
6	Гагнуурчин, огтлогч	2	2																										
7	Цахилгаан тоног төхөөрмжийн монтер	1	2																										
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn Огноо: 2020 оны 03-р сарын 20-ны өдөр Цаг: 10 цаг 00 минут</p>																												
ТӨӨЗ 2.1	<p>Тендер нээлт хийх газар хугацаа нь: Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн захиргаа, 2 давхар 215 тоот Огноо: 2020 оны 03-р сарын 20-ны өдөр Цаг: 10 цаг 05 минут</p>																												
ТӨӨЗ 2.3	<p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд: ТШӨХ-д заасан мэдээллүүд</p>																												
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй</p>																												

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Гүйцэтгэгч нь батлагдсан ажлын эзэлхүүнд тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэх бөгөөд тус ажлын хүрээнд ажилд зайлшгүй хэрэглэгдэх техник тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгсэл нийлүүлж хийгдэх сэлбэг материал болон бусад шаардлагатай материалыг хүрэлцэхүйц хэмжээгээр төсөвлөн, үнэлж ирүүлнэ.

Мөн ажлын үед шаардагдах жижиг хийцүүдийг гүйцэтгэгч бүрэн хариуцахаар төсөвт тусгаж ирүүлнэ.

Хэрэв нийлүүлэгдсэн сэлбэг материал нь стандарт шаардлагад нийцэхгүй, цаашид тоноглолын ажиллагаанд саад учруулхуйц байвал захиалагч тухайн сэлбэг материалаас татгалзаж шинийг нийлүүлхийг шаардах бөгөөд үүнээс шалтгаалан хугацаа хоцорсон тохиолдолд хугацааны торгуулийг гүйцэтгэгч талд тавих эрхтэй.

Ажлыг гүйцэтгэхдээ засварын технологуюдыг чанд баримталж ажиллах, шаардлагатай үед холбогдох мэргэжилтэнүүдтэй зөвлөлдөж тусгай технологи гаргаж түүний дагуу ажлыг гүйцэтгэх ёстой. Дур мэдэн ямар нэг өөрчлөлт, технологи хэрэглэхгүй байх.

ТЕНДЕРИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

1. Ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах хийц, эд ангиуд, тэдгээрийг монтажаас буулгах, угсрах, суурилуулах ажлын хөлс болон бусад зардлыг гүйцэтгэгч бүрэн хариуцах бөгөөд зардлуудыг сонгон шалгаруулалтын материалд тусгасан байвал зохино.
2. Гүйцэтгэгч байгууллага өөрсдийн гүйцэтгэх ажлын явцад мэргэжлийн удирдлагаар тасралтгүй хангаж ажлын тасралтгүй жигд зохион байгуулах, хүрэлцэхүйц мэргэжилийн ажилчдаар зохих хугацаанд нь гүйцэтгүүлэх үүрэг хүлээнэ.
3. Гүйцэтгэгч компани ХАБЭА-н байцаагч инженер томилон ажиллуулна. Ажлын явцад ХАБЭА-н зөрчил доголдолгүй ажиллуулах ажил зохион байгуулах үүргийг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажлын нарыдаар үүрэг хүлээгчид шууд хариуцна.

1. ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГАД ТАВИГДАХ ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРУУЛ АХУЙН ШААРДЛАГА

1. Гүйцэтгэгч байгууллагын (түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч мөн адил хамаарна) ажиллагсад нь Эрчим хүчний үйлдвэрт мөрдөгдөж байгаа ТАД, ААД, ГАУСД, ХАБЭА хуулийн зохих мэдлэгтэй ээлжит шалгалт өгсөн мэргэжлийн үнэмлэхтэй, оосорлогч дохиочноор ажиллах хүмүүс мэргэжлийн үнэмлэхтэй байна.
2. Тухайн ажлын байранд ажиллах хүмүүс нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын тусгай гутал, хувцасаар бүрэн хангагдсан, эрүүл мэндийн үзлэгт орсон, энэ ажилд эрүүл мэндээр тэнцэх хүмүүс байна.
3. Ажлын байрыг байнга эмх цэгцтэй, хог хаягдлыг тухай бүр нь зайлуулж, шат тавцангууд болон эд ангиудыг шуурхай ажиллагаанд /ашиглалтын ажилд/ саад болохооргүй чөлөөтэй байлгах үүрэг хүлээнэ.
4. Ажиллагсад нь “ДЦС-3” ТӨХК-ийн дотоод дүрэм журам, ХАБЭА-н талаар мөрдөгдөж байгаа дүрэм, журам эдгээрийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, торгууль, шийтгэлийг мөн адил мөрдөж ажиллах үүрэгтэй.
5. Ажлын онцлогоос хамааруулж тусгай шат тавцан барих, аюулгүйн зон татах, анхааруулах тэмдэг плакат өлгөх, шаардлагатай гэж үзвэл доош юм унахаас сэргийлсэн тор татах хүртэл ажил зохион байгуулахыг гүйцэтгэгч байгууллагын удирдлага, ажил удирдагч, ажил гүйцэтгэгч, ХЭБЭА-н ажилтан нар шууд хариуцна.
6. Ажлын байранд галын хэсгийн зөвшөөрөлгүй, галын нарядгүйгээр гагнуурын болон галын аюултай ажил гүйцэтгэх, ил гал түлэх, тамхи татахыг хориглоно.
7. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтанд хамрагдаж гэрчилгээ авсан, ХАБЭА-н орон тооны ажилтанг тушаалаар томилон засварын ажил гүйцэтгэх хугацаанд байнга хяналт тавиулж ажиллана.



БАТЛАВ: ДЦС-3 ТӨХК
ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ, ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Л.НЯМХҮҮ



**2020 онд ӨДТ цехийн ТГ №9-ын конденсаторын эргэлтийн буцах
усыг ӨДЗ цехийн СМН-ын баканд холбох шугамын ажлын эзэлхүүн**

11/11/2019

№	Хийгдэх ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	ТГ №9-ын конденсаторын эргэлтийн усны буцах шугамаас СМН-ын бак хүртэлх Ф159 шугам хоолой шинээр татах	м	260	
2	ӨДЗ цехийн 0.0 тэмдэгтэт байрлах техникийн усны коллекторт (Ф219) секцион Ду200 Ру16 хаалт шинээр суурилуулах	ш	1	
3	Эргэлтийн усны шинээр суурилуулах сливийн шугамны конденсатороос гарах тал болон СМН-ын бакны орох талд Ду150 Ру16 хаалт суурилуулах	ш	3	
4	Шинээр суурилагдсан шугаманд дренажийн вентиль Ду32 Ру16 хийх	ш	4	
5	Шинээр суурилагдсан шугаманд агаар гаргагч вентиль Ду10 Ру16 хийх	ш	3	
6	Эргэлтийн усны конденсаторт орох шугамнаас хөргөлтийн усны коллекторт холбосон хөргөлтийн (Ф108) шугамыг демонтаж хийж буулгах	м	40	
7	Сүлжээний усны халаагч №7 болон №8-ын конденсатын шугамны чиглэлийг өөрчлөн татах	м	24	
8	ӨДЗ цехийн ШБМ 8Б болон ШБМ 9А -ын дундуур суваг татаж шугам суурилуулан бетон цутгах	м3	5	Үндсэн канал хүртэл шугам явуулах суваг татах (21x0.4x0.4)
9	ӨДЗ цехийн СМН-ын бакруу явах каналын (газар доорх) бетоныг хуулж, каналыг ил гаргах	м3	20	Газар доогуур явж буй каналаар шугам татах (40x0.5x1)
10	ӨДЗ цехийн СМН-ын бакруу явах каналд шугам суурилуулж, бетон цутгах	м3	20	Газар доогуур явж буй каналаар шугам татах (40x0.5x1)
11	Цахилгааны хүчний кабелийн трассуудын байрлалыг өөрчлөх	м	2	
12	Зуухан цехийн газар доогуур явах хэсгийн шугамыг зэврэлтээс хамгаалах будгаар 2 давхарлаж будах	м2	35	<i>Т.Инжир</i> <i>Тосов мин</i>
13	ТГ №9-ын конденсаторын эргэлтийн усны буцах цэгээс зуухны тээрмийн хана хүртэлх Ф159 шугамыг 2 давхарлаж будах	м2	100	<i>Ц.У</i> <i>11/11</i>
14	Шугамыг ажилд залгаж гарсан гэмтлүүдийг засварлах	удаа	1	

Шаардлагатай сэлбэг материалын жагсаалт

№	Шаардлагатай материал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар
1	Хаалт, Ду200 Ру16 (фланцтай)	ш	1	
2	Хаалт, Ду150 Ру16 (фланцтай)	ш	2	
3	Вентиль Ду32 Ру16	ш	4	
4	Агаар гаргагч, Ду10 Ру16	ш	2	
4	Труба Ф159х4мм	м	260	
5	Булан Ф159х4мм	ш	30	
6	Булан Ф159ммх4 (Бойлерийн конденсатын шугам)	ш	6	
7	Труба Ф32х3мм	м	3	
8	Тулгуур (швеллер 12)	м	30	
9	Бетон зуурмаг	м3	25	
10	Электрод	кг	80	
11	Огтлогч чулуу	ш	30	
12	Өнгөлгөөний чулуу	ш	30	
13	Зэврэлтээс хамгаалах будаг	л	14	
14	Будаг	л	40	
15	Өнхрүүш	ш	6	
16	Багс	ш	10	

Хянасан: ҮА-ны дарга

ЗХА-ны дарга

ӨДТ цехийн дарга

ӨДЗ цехийн дарга

Цахилгаан цехийн дарга

Нормчлолын инженер

Ажлын эзэлхүүн гаргасан:

ГТХ-ын тооцооны инженер

Л.Бөхболд

Ц.Батмагнай

Э.Нямдаваа

П.Болдбаатар

П.Мөнхбаяр

Ж.Гочоо

Б.Мөнхсүх

Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

(а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;

(б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
7. **Ажлын хөтөлбөр** **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**
7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил, гологдол арилгах** 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
10. **Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах** 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
- (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
- (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
- (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
- (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

**19. Гэрээг
цуцалсан үед
хийх төлбөр**

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

**20. Гүйцэтгэлээс
чөлөөлөх**

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Хөргөх цамхаг №2-ын усны хатуулаг бууруулах ажил
ГЕН 2.1	Ажил нь <i>[товч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ. Ажлын талбай нь <i>[байршил]</i> -д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь : <i>“ДЦС-3” ТӨХК, Өндөр даралтын турбин цехийн дарга Э.Нямдаваа</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2020.05.01 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020.06.15
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 90 хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг 2020.07.01 -ны дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ⁵

БАТЛАВ
“ДЦС-3” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Ч.ЧИНБАТ

БАТЛАВ
“.....” ХХК-ИЙН ЗАХИАРЛ

.....

..... ИХ ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2020 оны -р сарын . . .-ны өдөр

№.....

Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

Нэг талаас “ДЦС-3” ТӨХК-г төлөөлж Тэргүүн дэд захирал, ерөнхий инженер /цаашид “захиалагч” гэх/, нөгөө талаас “.....” ХХК-ийг төлөөлж инженер /цаашид “гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343–358 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйл, “ДЦС–3” ТӨХК-ийн Харьцуулалтын ажлын хэсгийн 20.... оны-р сарын-ны өдрийн хурлын тоот шийдвэр, Харьцуулалтын ажлын хэсгийн тоот зөвлөмж, 2020 оны Бизнес төлөвлөгөө, Удирдлагын шийдвэрийг үндэслэн харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

“.....”-ын ажлыг тендерийн баримт бичигт заасан шалгаруулалт, шаардлагад нийцүүлэн график хугацаанд чанартай, технологийн дагуу хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөх, захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох, төлбөр тооцоог гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэхэд гэрээний зорилго оршино.

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. “.....”-ын ажлыг 2020 оны-р сарын-ноос 2020 оны -р сарын -ний хооронд багтаан хийж хүлээлгэн өгнө.

1.2. Гэрээт ажлын үнэ Харьцуулалтын ажлын хэсгийн тоот зөвлөмжийн дагуу НӨАТ болон бусад бүх зардлыг тооцоод /...../ төгрөг байна.

1.3. Гэрээт ажлын хөлсний 90%-ийг гэрээт ажлыг хүлээн авч, гэрээ дүгнэсэн акт батлагдсанаас хойш хуанлийн 30 хоногт багтаан шилжүүлнэ.

ХОЁР. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаанд хүлээн авч санхүүжилтийг гэрээ дүгнэсэн акт болон нэхэмжлэлийг үндэслэн хийж гүйцэтгэнэ

2.2. Гүйцэтгэсэн ажлыг хугацаанд комисс гарган хүлээн авна.

2.3. Баталгаат хугацаа хүлээлгэн өгснөөс хойш 3 сар буюу 2200 цаг ажилласан байна. Гэрээт ажлын баталгаат хугацаа дууссаны дараа баталгаат хугацааны 10%-г олгох хурлын тэмдэглэлийг үндэслэн гүйцэтгэгч талд шилжүүлнэ.

⁵ Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

2.4. Баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой гэмтэл доголдол гарвал дахин үнэ төлбөргүй хийж гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Гэрээт ажлыг гэрээнд заасан хугацаанд технологийн дагуу чанартай хийж хүлээлгэн өгнө.

3.2. “.....”-ын ажилтай холбогдолтой техникийн бичиг баримтыг бүрдүүлэх.

3.3. Гэрээт ажил нь чанарын шаардлага хангахгүй тохиолдолд гүйцэтгэгч хугацаа алдалгүй өөрийн хүчээр хийж өгөх ба гарсан бүх зардлыг хариуцна.

3.4. Гэрээт ажлын хугацаанд ХАБЭА-н болон бусад аюулгүй ажиллагааны бүх арга хэмжээг бүрэн хариуцаж ажиллана.

3.5. Баталгаат хугацаанд гэрээт ажлын хөлсний 10%-ийг захиалагчийн дансанд байршуулна.

ДӨРӨВ. ГЭРЭЭ ДҮГНЭЖ ХАРИУЦЛАГА ТООЦОХ

4.1 “.....”-ын ажлыг бүрэн дуусгаж техникийн бичиг баримт бүрдэлтийг хийж захиалагч талд хүлээлгэн өгч гэрээг дүгнэнэ.

4.2. Гүйцэтгэгчийн буруугаас засварын ажлын хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн дүнгийн 0.3 хувиар хоног тутам гүйцэтгэгч алданги хүлээх ба уг алданги нийт гэрээний үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

4.3. Захиалагчийн буруугаас төлбөр төлөх хугацаа хэтэрвэл гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувиар хоног тутам алданги хүлээх ба нийт үнийн дүнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

5.1. Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гамшиг, гал түймэр, үер, шуурга, газар хөдлөлт, дайн, эдийн засгийн болон импортын шууд хориг, энэ гэрээг баталсны дараа үүсч болзошгүй онцгой байдалд хүргэсэн бусад нөхцлүүд гэрээг биелүүлэхэд саад учруулсан зүйлүүд орно.

5.2. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас шууд шалтгаалан энэ гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн буюу бүхлээр нь биелүүлэхгүйд хүрсэн бол талууд хариуцлагыг хүлээхгүй.

5.3. Давагдашгүй хүчин зүйл үүссэнээс хойш 7 хоногийн дотор гэрээний үүргээ биелүүлэх бололцоогүй болсон тал нь нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.

5.4. Хэрэв давагдашгүй хүчин зүйлс гэрээний биелэлтэнд 1 сарын турш үйлчлэх тохиолдолд үүргээ биелүүлж чадахгүй болсон тал цаашид энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй татгалзах эрхтэй. Энэ тохиолдолд талууд гэрээг хүчингүй болсон хугацаагаар ажлын гүйцэтгэлийн тооцоог дуусгана.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1. Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

6.2. Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж гүйцэтгэгч нэг хувь, захиалагч гурван хувийг авах бөгөөд хувиуд нь ижил тэгш хүчинтэй.

6.3. Талууд аль нэг нь гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.

6.4. Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6.5. Талуудын санал зөрөөтэй асуудлаар зөвшилцөлд хүрч чадахгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

6.6. Шүүхийн шийдвэр нь эцсийн бөгөөд талууд түүнийг заавал биелүүлнэ.

6.7. Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.

6.8. Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.

ДОЛОО. ТАЛУУДЫН ХАЯГ:

ЗАХИАЛАГЧИЙН ХАЯГ:

Хаяг: Хан–Уул дүүрэг. 3-р хороо
“ДЦС–3” ТӨХК-ийн байр
Утас: 11–343024

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ХАЯГ:

..... дүүрэг ,-р хороо
.....
РД:
Утас:
Банк:
Данс:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ДЦС-3” ТӨХК–ийн Тэргүүн дэд
захирал, ерөнхий инженер

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“.....” ХХК-ийн
инженер
.....

ТБХ-ийн дарга

СБХ –ийн дарга

Ерөнхий нягтлан бодогч

ӨДТ цехийн дарга

Гэрээний мэргэжилтэн

Хянасан: Хуулийн мэргэжилтэн